



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын Театрын музейн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/194/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p> | <p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 261885 Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр Утас:70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p> |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/299
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын театрын музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын театрын музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын театрын музей нь урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалан хойч үедээ уламжлуулж, иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэх чиглэлийг баримтлан үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд 1 удирдах, 7 гүйцэтгэх, 2 үйлчлэх, нийт 10 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 1 удирдах, гүйцэтгэх албан тушаалд 7, үйлчлэх албан тушаалд 2 хүн ажиллаж, батлагдсан бүтэц орон тоогоор ажилласан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хүрээнд Соёлын яамнаас хэрэгжүүлж буй “Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд 2023 оны 6 дугаар сард Говьсүмбэр аймагт зохион байгуулсан арга хэмжээнд оролцож, урлагийн тоглолтын зардалд 6,250.0 мянган төгрөг, томилолтын зардалд 6,608.0 мянган төгрөг, бусад бараа, ажил үйлчилгээний зардалд 12,479.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн хүрээнд 2023 оны Соёлын яамнаас байгууллагын үр дүнгийн нэмэлт санхүүжилт 106,145.8 мянган төгрөгийг хүлээн авч, уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажилд 31,812.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 42,448.1 мянган төгрөг, ажилтан албан хаагчдын урамшууллын зардалд 15,921.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 15,921.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллага жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 11,009,058.57 | 27,953,696.96 |
| 33 | АВЛАГА | 90,226.57 | 326,385.96 |
| 335 | Бусад авлага | 90,226.57 | 326,385.96 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 90,226.57 | 326,385.96 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 10,918,832.00 | 27,627,311.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 280,980.00 | 280,980.00 |
| 354 | Хангамжийн материал | 10,637,852.00 | 27,346,331.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 144,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,040,077.00 | 11,442,456.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,597,775.00 | 15,759,775.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 824,242,387.05 | 882,670,730.77 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 824,242,387.05 | 882,670,730.77 |
| 392 | Биет хөрөнгө | 824,037,127.33 | 873,533,891.09 |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 30,953,403.00 | 85,524,853.67 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (23,039,049.28) | (29,817,872.30) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,249,198.96 | 48,817,198.96 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,480,497.20) | (33,448,194.24) |
| 39213 | Түүх соёлын дурсгалт зүйлс | 798,483,020.00 | 798,483,020.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,877,250.00 | 6,022,750.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,835,583.15) | (4,877,250.00) |
| 39217 | Номын фонд | 2,829,385.00 | 2,829,385.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 205,259.72 | 9,136,839.68 |
| 39301 | Программ хангамж | 684,200.00 | 684,200.00 |
| 39302 | Хасагдуулаг | (478,940.28) | (547,360.32) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 9,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 835,251,445.62 | 910,624,427.73 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 835,251,445.62 | 910,624,427.73 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 835,251,445.62 | 910,624,427.73 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 70,433,859.73 | 70,433,859.73 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 70,433,859.73 | 70,433,859.73 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 44,097,652.89 | 119,470,635.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 52,283,766.82 | 44,097,652.89 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (8,186,113.93) | 75,372,982.11 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 720,719,933.00 | 720,719,933.00 |
| | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 835,251,445.62 | 910,624,427.73 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 236,350,440.00 | 436,444,750.67 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,956,000.00 | 38,942,250.67 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,956,000.00 | 38,942,250.67 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 3,956,000.00 | 38,942,250.67 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,956,000.00 | 38,942,250.67 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 232,394,440.00 | 397,502,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 213,692,900.00 | 358,506,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 213,692,900.00 | 358,506,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 18,701,540.00 | 38,996,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 15,730,000.00 | 35,430,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,971,540.00 | 3,566,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 244,536,553.93 | 361,071,768.56 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 244,536,553.93 | 361,071,768.56 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 224,110,489.34 | 358,300,369.95 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 132,892,206.23 | 201,533,643.52 |
| 210101 | Цалин | 90,829,968.44 | 120,229,367.72 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 23,675,938.53 | 37,632,358.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,946,234.00 | 16,104,526.67 |
| 210104 | Урамшуулал | 8,440,065.26 | 27,567,390.85 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,549,902.61 | 24,797,098.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 10,779,642.23 | 17,294,014.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,260,878.37 | 2,080,776.11 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,042,970.93 | 1,620,520.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 224,219.20 | 341,762.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 2,242,191.88 | 3,460,024.59 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,065,900.00 | 30,978,600.00 |
| 210304 | Байрны түрээс | 31,065,900.00 | 30,978,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,440,523.00 | 6,869,931.00 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 843,633.85 | 893,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | - | 3,454,400.00 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 777,945.15 | 778,800.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 250,000.00 | 100,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 568,944.00 | 1,642,931.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 18,603,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,145,500.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 17,458,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 7,080,000.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | - | 7,080,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 31,146,640.00 | 41,802,190.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,543,740.00 | 39,747,190.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 378,200.00 | 55,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 224,700.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,015,317.80 | 27,780,606.95 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 325,700.00 | 15,924,000.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 187,600.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,502,017.50 | 11,856,606.95 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,426,064.59 | 2,771,398.61 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,554,400.00 | 1,526,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,054,400.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 500,000.00 | 1,526,400.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,871,664.59 | 1,244,998.61 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,871,664.59 | 1,144,098.61 |

| | | | |
|----------|--|-----------------------|----------------------|
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 100,900.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (8,186,113.93) | 75,372,982.11 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | (8,186,113.93) | 75,372,982.11 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 238,386,440.00 | 397,502,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 238,386,440.00 | 397,502,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 213,692,900.00 | 358,506,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 213,692,900.00 | 358,506,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 24,693,540.00 | 38,996,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 15,730,000.00 | 35,430,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,963,540.00 | 3,566,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 233,736,440.00 | 367,305,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 233,736,440.00 | 367,305,300.00 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 213,310,375.41 | 364,533,901.39 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 132,892,206.23 | 201,679,576.34 |
| 210101 | Үндсэн цалин | 90,829,968.44 | 120,375,300.54 |
| 210102 | Нэмэгдэл | 23,675,938.53 | 37,632,358.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,791,234.00 | 16,104,526.67 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 7,595,065.26 | 27,567,390.85 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,640,129.18 | 24,887,325.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 11,776,633.37 | 17,384,241.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,354,113.80 | 2,080,776.11 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,042,970.93 | 1,620,520.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 224,219.20 | 341,762.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 2,242,191.88 | 3,460,024.59 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 31,065,900.00 | 30,978,600.00 |
| 210304 | Байрны түрээс | 31,065,900.00 | 30,978,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,847,000.00 | 7,526,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 370,054.85 | 650,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 5,220,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 777,945.15 | 778,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 100,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 449,000.00 | 778,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 53,500.00 | 23,890,500.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 53,500.00 | 464,800.00 |
| 210602 | Тавилга | - | 2,332,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 3,635,300.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 17,458,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 7,080,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 7,080,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 30,182,840.00 | 52,045,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 27,579,940.00 | 49,750,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 378,200.00 | 185,400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 224,700.00 | 109,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 628,800.00 | 16,445,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 416,200.00 | 16,095,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 212,600.00 | 350,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,426,064.59 | 2,771,398.61 |

| | | | |
|-------------|--|-----------------------|------------------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,554,400.00 | 1,526,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 17,054,400.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 500,000.00 | 1,526,400.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,871,664.59 | 1,244,998.61 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,871,664.59 | 1,144,098.61 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 100,900.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 4,650,000.00 | 30,197,200.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 4,650,000.00 | 30,197,200.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,650,000.00 | 30,197,200.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,650,000.00 | 30,197,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,650,000.00 | 30,197,200.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (4,650,000.00) | (30,197,200.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------|-----------------------|-----------------------|--|
| 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 70,433,859.73 | 720,719,933.00 | 52,283,766.82 | 843,437,559.55 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 70,433,859.73 | 720,719,933.00 | 52,283,766.82 | 843,437,559.55 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (8,186,113.93) | (8,186,113.93) |
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 70,433,859.73 | 720,719,933.00 | 44,097,652.89 | 835,251,445.62 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 70,433,859.73 | 720,719,933.00 | 44,097,652.89 | 835,251,445.62 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 75,372,982.11 | 75,372,982.11 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 70,433,859.73 | 720,719,933.00 | 119,470,635.00 | 910,624,427.73 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-----------------------|-----------------------|---------------------|--------------|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 358,533,200.00 | 357,362,401.39 | 1,170,798.61 | 99.7 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 358,533,200.00 | 357,362,401.39 | 1,170,798.61 | 99.7 |
| Бараа, үйлчилгээний зардал | 358,211,700.00 | 357,262,401.39 | 949,298.61 | 99.7 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 201,684,300.00 | 201,679,576.34 | 4,723.66 | 100.0 |
| Үндсэн цалин | 114,126,900.00 | 120,375,300.54 | (6,248,400.54) | 105.5 |
| Нэмэгдэл | 43,651,800.00 | 37,632,358.28 | 6,019,441.72 | 86.2 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 19,500,000.00 | 16,104,526.67 | 3,395,476.33 | 82.6 |
| Урамшуулал | 24,405,600.00 | 27,567,390.85 | (3,161,790.85) | 113.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,547,700.00 | 24,887,325.05 | 660,374.95 | 97.4 |
| Тэтгэврийн даатгал | 17,483,100.00 | 17,384,241.07 | 98,858.93 | 99.4 |
| Тэтгэмжийн даатгал | 2,016,400.00 | 2,080,776.11 | (64,376.11) | 103.2 |
| ҮОМШӨ ний даатгал | 1,612,500.00 | 1,620,520.81 | (8,020.81) | 100.5 |
| Ажилгүйдлийн даатгал | 403,400.00 | 341,762.47 | 61,637.53 | 84.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 4,032,300.00 | 3,460,024.59 | 572,275.41 | 85.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,065,900.00 | 30,978,600.00 | 87,300.00 | 99.7 |
| Байрны түрээс | 31,065,900.00 | 30,978,600.00 | 87,300.00 | 99.7 |
| Хангамж, бараа материалын зардал | 2,306,900.00 | 2,306,900.00 | - | 100.0 |
| Бичиг хэрэг | 600,000.00 | 650,100.00 | (50,100.00) | 108.4 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 778,800.00 | (178,800.00) | 129.8 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал | 106,900.00 | 100,000.00 | 6,900.00 | 93.6 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 778,000.00 | 222,000.00 | 77.8 |
| Эд хогшил худалдан авах | 42,958,300.00 | 42,948,100.00 | 10,200.00 | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 10,500,000.00 | 10,500,000.00 | - | 100.0 |
| Тавилга | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 5,000,000.00 | 4,989,800.00 | 10,200.00 | 99.8 |
| Урсгал засвар | 17,458,300.00 | 17,458,300.00 | - | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 38,187,600.00 | 38,016,300.00 | 171,300.00 | 99.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,892,100.00 | 35,721,000.00 | 171,100.00 | 99.5 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| Мэдээллийн технологийн зардал | 185,400.00 | 185,400.00 | - | 100.0 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 110,100.00 | 109,900.00 | 200.00 | 99.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 16,461,000.00 | 16,445,600.00 | 15,400.00 | 99.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 16,111,000.00 | 16,095,600.00 | 15,400.00 | 99.9 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 350,000.00 | 350,000.00 | - | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 321,500.00 | 100,000.00 | 221,500.00 | 31.1 |
| Бусад урсгал шилжүүлэг | 321,500.00 | 100,000.00 | 221,500.00 | 31.1 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 321,500.00 | 100,000.00 | 221,500.00 | 31.1 |
| Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | - | - | - |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - | - | - |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 358,533,200.00 | 357,362,401.39 | 1,170,798.61 | 99.7 |

| | | | | |
|-------------------------------------|-----------------------|-----------------------|---------------------|--------------|
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 358,533,200.00 | 357,362,401.39 | 1,170,798.61 | 99.7 |
| Улсын төсвөөс санхүүжих | 358,533,200.00 | 357,362,401.39 | 1,170,798.61 | 99.7 |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 10 | 10 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|--|------------|----------------------|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 38,996,000.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 38,996,000.00 |
| Бараа, үйлчилгээний зардал | - | 37,468,700.00 |
| Хангамж, бараа материалын зардал | - | 5,220,000.00 |
| Тээвэр (шатахуун) | - | 5,220,000.00 |
| Эд хогшил худалдан авах | - | 2,139,600.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | - | 2,139,600.00 |
| Томилолт, зочны зардал | - | 7,080,000.00 |
| Дотоод албан томилолт | - | 7,080,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | - | 23,029,100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 23,029,100.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 1,527,300.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | - | 1,426,400.00 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | - | 1,426,400.00 |
| Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 100,900.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 100,900.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 38,996,000.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 38,996,000.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 35,430,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,566,000.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,145.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,145.5 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|----------------|-----------------------------------|----------|--------------------------|----------------|------------|----------------|--------------|----------|----------|----------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад үндсэн хөрөнгийг орлогод бүртгэж авахтай холбоотой засгийн газрын хувь оролцоо данс 1,145.5 зөрүүтэй тайлагнасан. | 1 | 1,145.5 | - | - | 1 | 1,145.5 | 1 | 1,145.5 | - | - | - | - |
| Дүн | 1 | 1,145.5 | - | - | 1 | 1,145.5 | 1 | 1,145.5 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 1,418.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 152.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,266.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|---------|---------------|-------|-----------------|-----|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагын хөрөнгөөр 152.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна. | 1 | 152.0 | 1 | 152.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Бараа материалын тайланд шаардах хуудасгүй, шаардах хуудас болон зарлагын баримтад барааг олгосон тоо хэмжээ байхгүй, тамга тэмдэггүй, олгосон | 1 | 1,116.2 | - | - | - | - | 1 | 1,116.2 | - | - | - | - |

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|--|----------|----------------|----------|--------------|---|---|----------|----------------|---|---|---|---|
| дүн зөрүүтэй зэрэг 1,116.2 мянган төгрөгийн гүйлгээг бүртгэсэн. | | | | | | | | | | | | |
| Ажилчдаас суутгах нийгмийн даатгалын шимтгэлийг 150.7 мянган төгрөгөөр илүү тооцоолон суутгаж авсан байна. | 1 | 150.7 | - | - | - | - | 1 | 150.7 | - | - | - | - |
| Байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, түүний тодруулгыг Сангийн сайдын баталсан журам, заавар аргачлалын дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 12,700.3 мянган төгрөгийн 15 хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Дүн | 5 | 1,418.9 | 1 | 152.0 | - | - | 4 | 1,266.9 | - | - | - | - |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 78,492.2 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 78,492.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | |
|--|-------------|-----------------|--------------------|-----|----------|-----------------|
| | | | Үүнээс | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 445,460.2 мянган төгрөгийн 22 ажил гүйлгээнээс 78,492.2 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг байршуулаагүй байна. | 1 | 78,492.2 | - | - | 1 | 78,492.2 |
| Дүн | 1 | 78,492.2 | - | - | 1 | 78,492.2 |

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.